Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Пүрэвсүх Түвшин

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | |
| 1 | Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна. | Гүйцэтгэлийн явц, хувиар | 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын хавсралтад туссан 53 төсөл, арга хэмжээний гэрээг боловсруулан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээг байгуулсан болно. | Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна. /100 хувь/ | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гэрээ: 1.Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны тушаалаар дагуу байгуулагдсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 8 гэрээг шинээр байгуулсан /3 гэрээ нь төсөв хэмнэлтэд тооцогдож, татагдсан тул цуцлагдсан/. 2.Мөн 2024 онд байгуулсан ТЭЗҮ гэрээнүүдэд 32 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлуулсан байна. | | |
| 2 | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ | Гүйцэтгэлийн явц, хувиар | Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянагдсан. | Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/ | 2025 онд яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих 59 албан бичгийн төсөл, 10 тушаалын төсөл боловсруулж, хүргүүлсэн. Хуулийн хэлтсийн зүгээс Эдийн засаг, хөгжлийн яамны бусад нэгжид санал хүргүүлэх, санал авах, мэдээлэл хүргүүлэх зорилгоор нийт 40 дотоод бичгийн төсөл боловсруулж, тухай бүр хүргүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 98% |
| 3 | Монгол Улсын Засгын газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр төлөөлөх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах | Гүйцэтгэлийн явц, хувиар | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан. | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/ | 1. "Пик девелопмент" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох иргэний хэргийн тухайд Эдийн засаг, хөгжлийн яамыг хамтран хариуцагчаар татсан. Тус шүүх хуралд тайлант хугацаанд дараах байдлаар оролцсон байна. • 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр тус маргааныг Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гомдлын дагуу Нийслэл дэх иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хэлэлцэж, нэхэмжлэлийн шаардлагаас 8,278,461,839 төгрөгийг хэрэгсэхгүй болгож, 8,262,456,796 төгрөгийг Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргуулахаар шийдвэрлэсэн. • 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгч миний гомдлыг Улсын Дээд шүүх “хууль хэрэглээний зөрүүг арилгах” үндэслэлээр хүлээн авч хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Улмаар тус хэргийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Улсын Дээд шүүх хяналтын шатны шүүх хуралдаанаа хийж, нэхэмжлэгч Пик девелопмент ХХК-ийн 16,549,918,635.53 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн. 2. "Огторгуйн цамхаг" ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэгт Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 3 удаагийн шүүх хуралд оролцож, Эдийн засаг, хөгжлийн яаманд ашигтай нөхцөлөөр нэхэмжлэгч талтай эвлэрүүлэх арга хэмжээ авч ажилласан. 3. Концессын гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгээгүйтэй нь холбогдуулан Хос мөнгөн зам ХХК-аас хохирол нэхэмжилэхээр ХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын арбитрт нэхэмжлэл гаргасан. Тус нэхэмжлэлийг арбитр хүлээн авч хэрэг үүсгэсэн ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа арбитрын бүрэлдэхүүн томилох шатанд явагдаж байна. 3. Алтай трест | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэгт/2025 оны 11 дүгээр сард нэхэмжлэл ирсэн/ яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна/Одоогийн байдлаар тус хэргийн шүүх хурлын тов тодорхойгүй байна/ | | |
| 4 | Яамнаас байгуулах гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, боловсруулах | Гүйцэтгэлийн явц, хувиар | - | Гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. | Нэгжийн удирдлагаас хянуулахаар өгсөн гэрээний төслүүдийг тухайн бүр хянаж, зөвлөгөө өгч ажилласан болно. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 93% |
| 5 | Монгол Улсын Засгын газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон захиргааны хэрэг | Гүйцэтгэлийн явц, хувиар | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан. | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан | 1.Монгол Улсын Ерөнхий сайдаас олгосон итгэмжлэлийн дагуу "Баянгол ресорт" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | 100% |

8-7

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр төлөөлөх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах | | | байна. /100 хувь/ | холбогдох захиргааны хэрэгт Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Одоогийн байдлаар тус хэргийн урьдчилан хэлэлцүүлэг товлогдоогүй байна. 2.Эн Си Эф ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус холбогдох захиргааны хэрэг /Нэхэмжлэлийн үнийн дүн 12 тэрбум/-т яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. /Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс урьдчилсан хэлэлцүүлгээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргасан хүсэлт, тайлбарын дагуу Эн Си ЭФ ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлээд байгаа болно/. 3. Кью Эс Си ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгт Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт дэмжлэг үзүүлж ажилласан. | | |
| 6 | Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах | Гүйцэтгэлийн явц, хувиар | - | Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна. | 1. Тайлант хугацаанд 1/Яамны Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, 2/Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөлийн ажиллах журмын төслийг тус тус өөр дээрээ шилжүүлэн авч, бие даан боловсруулж батлуулсан. 2: Засгийн газрын 11 дүгээр байрны 12 дугаар давхарын түрээслэгч сонгон шалгаруулах ажлын хэсэг, Хөгжлийн банкны ТУЗ-ын хараат бус 3 гишүүн сонгон шалгаруулах ажлын хэсэг /нарийн бичгийн даргаар бүх ажлыг гардан хийсэн/, Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд тооцох үнэлгээ хийх ажлын хэсэг /МУИС, ШУТИС/ зэрэгт гишүүнээр орж ажилласан. 3. Концессын гэрээгээр | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 94% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжиж буй Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамын ажилтай танилцах, үзлэг хийхээх Өмнөговь аймагт аймагт ажилласан. 4. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Засгийн газраас батлагдан, хэрэгжиж байгаа хэм хэм тогтоосон актуудад, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн баталсан “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох журмуудыг бүхэлд нь хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг хуульд тусгах санал хүргүүлэх ажилд чиг үүргийн дагуу оролцсон. | | |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |

9б

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Тогтоосон хугацаанд үнэн зөв боловсруулах | 2024 онд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь боловсруулсан болно. | 2025 онд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсээр хугацаанд нь боловсруулсан байна. | Тайлант хугацаанд төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хууль тогтоомжип заасан хугацаанд нь боловсруулж, тайлагнасан байна. Мөн түүнчлэн яамнаас биелэлт нь гарах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тухай бүх гарган нэгтгэлийн хүснэгтэд оруулж байсан ба яамнаас биелэлт гарахааргүй ажлыг холбогдох албан тушаалтанд хандан хасуулах ажлыг зохион байгуулсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 8 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн | Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах. | 2024 онд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн | Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

9/

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | | хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг тухай бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилласан. Тайлант хугацаанд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн ямар нэгэн зөрчил гаргаагүй болно. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан ажлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг | Хариуцсан ажлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг мэргэжлээ ахисан | 2024 онд богино болон урт хугацааны мэргэшүүлэх | Хариуцсан ажлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг, | Тайлан хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Эрх зүйн шинэтгэл 2 хөтөлбөрийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлээ ахисан түвшин дээшлүүлэх | түвшин дээшлүүлэх зорилгоор цахим болон танхимын сургалтуудад хамрагдах. | сургалтуудад хамрагдсан. | мэргэжлийн түвшинг дээшлүүлсэн байх | хүрээнд Захиргааны эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Хувийн эрх зүйн 3 удаагийн цуврал хэлэлцүүлэгт хамрагдсан. Сангийн яам, Боловсролын яамнаас хамтран зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын хуулийн төсөл"-ийн хэлэлцүүлэг, ХЗҮХ-ээс зохион байгуулсан "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем"-д хууль, захиргааны хэм хэмжээний акт байршуулж санал авах ажиллагааны талаар сургалт, Монголын Хуульчдын холбоо болон Эдийн засаг, хөгжлийн яамнаас хамтран зохион байгуулсан "Хуулийн төсөл боловсруулагчдын сургалт"-д тус тус хамрагдсан байна. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | |
| 2 | Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцох | Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцоно | - | Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | Тайлант хугацаанд Монгол хуульчдын холбооноос зохион байгуулсан "Төр, хувийн хэвшлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага " сэдэвт хэлэлцүүлэг, мөн "Миний дуртай захиргааны эрх зүй" сэдэвт цуврал өглөөний уулзалт, яаманд зохион байгуулагдсан "Тогтвортой дэд бүтцийн нөхцөл байдлын шинжилгээ" сэдэвт өглөөний уулзалт, "Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах", Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 97% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжил болон ногоон санхүүжилт, "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх" сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтуудад тус тус хамрагдсан болно | | |

ХЯНАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дашням Ариунбилэг /............................................................/ Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Пүрэвсүх Түвшин /............................................................/ Огноо: 2025.12.15

ТУ32801 6808236 9022010236